



МОНГОЛ УЛСЫН
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2014 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 127

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ТОГТООХ нь:

1."Шүүгч, ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шүүхийн төсөв, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан жил бүр төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Т.Мэндсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ЛҮНДЭНДОРЖ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2014
оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн
127 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮГЧ, АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХӨТӨЛБӨР

НЭГ.ЗОРИЛГО

Шүүгч, ажилтны нийгмийн баталгааг хангах, ажлын үр нөлөө, бүтээмжийг дээшлүүлэхэд энэ хөтөлбөрийн зорилго оршино.

ХОЁР.ЗОРИЛТ

(1) Ажиллах нөхцөл, (2) амьдрах нөхцөл.

ГУРАВ.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилт 1. Ажиллах нөхцөл

-Шүүгч, ажилтны цалингийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх.

-Ажлын байрны стандарт нөхцөлийг дээшлүүлэх боломжийг судалж, судалгааны үндсэн дээр олон улсын жишигт үе шаттайгаар нийцүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

-Шүүгч, ажилтныг шагнах, урамшуулах, нийгмийн хамгааллыг шударга хүртээмжтэй болгох ухаалаг тогтолцоонд шилжүүлэх.

-Шүүгч, ажилтны хөдөлмөрийн нөхцөлийг судлах, үнэлэх, сэтгэл зүйн үйлчилгээг бий болгох.

-Эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

-Шүүгч, ажилтан өөр шүүхэд шилжин ажиллах болсонтой холбогдож эхнэр /нөхөр/ нь ажлаас чөлөөлөгдсөн бол 3 сар хүртэлх хугацааны дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг олгох эрх зүйн үндсийг бүрдүүлэх.

-Алслагдсан орон нутагт ажиллаж байгаа шүүгч, ажилтанд бүсийн нэмэгдэл олгох, сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдийн боловсролыг дэмжих бодлого хэрэгжүүлэх.

-Шүүгч, ажилтны давтан сургалтын төв, цогцолбор байгуулах.

Зорилт 2. Амьдрах нөхцөл

-“Орон сууцны сан” байгуулах, хөнгөлөлттэй зээлд хамруулах, шүүгч, ажилтныг орон сууцтай болох, нөхцөлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх.

-Шүүгч, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаарх санаачилгыг дэмжих, бодлого гарган хэрэгжүүлэх.

-Шүүгч, ажилтныг нийгмийн даатгал, лизингийн болон бусад үйлчилгээний мэдээллээр хангах, хамрагдах үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх.

ДӨРӨВ.ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, САНХҮҮЖИЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН

Хөтөлбөрийг 2015-2020 оныг дуустал хэрэгжүүлнэ. Улсын төсөв болон Монгол Улсын олон улсын гэрээгээр нийлүүлэх хөрөнгө, зээл, тусламж, төсөл, хөтөлбөрөөр санхүүжүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

-Орон сууцтай болсон, орон сууцныхаа нөхцөлийг сайжруулсан шүүгч, ажилтны тоо.

-Байгууллагын мэдлийн орон сууцны тоо.

-Эрүүл мэндийн даатгалын сангаас төлсөн мөнгөний хэмжээний өсөлт, бууралт.

-Шүүгч, ажилтны шилжилт хөдөлгөөний статистик тоо.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

-Орон сууцтай болсон, нөхцөлөө сайжруулсан шүүгч, ажилтны тоо 20-иос доошгүй хувиар өссөн байна.

-Шүүгч, ажилтны амьдралын чанар дээшилсэн байна.

-Шүүгч, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах таатай нөхцөл нэмэгдэнэ.

-Шүүгч, ажилтан үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ.

-Шүүхийн үйлчилгээний үр нөлөө, бүтээмж, хариуцлага дээшилнэ.

оОо